

ДОРНОГОВЬ АЙМАГ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

2023.09.06
сум

Сайншанд

Дорноговь аймгийн Соёл урлагийн газар тайлант оны эхний хагас жилд том, жижиг 50 гаруй арга хэмжээг салбар нэгжтэйгээ хамтран зохион байгуулж, соёлын үйлчилгээг цахим орчинд 93800 гаруй иргэдэд хүргэлээ.

“ЭГШИГЛЭНТ ГОВЬ” СУМДЫН СОЁЛЫН ӨДӨР

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-II” үйл ажиллагааны хөтөлбөр, “Нээлттэй Дорноговь” зорилтот жил, Говийн ноён хутагт Данзанравжаагийн мэндэлсний 220 жилийн ойн хүрээнд 14 сумдыг хамруулсан “Эгшиглэнт говь” соёлын өдрийг зохион байгуулсан. Соёлын өдрүүдээр нутгийн зөвлөлийн уулзалт, гар урлал болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн, худалдаа, сум сурталчлах урлагийн тоглолтыг олон нийтийн хүртээл болгосон. Аймгийн DSB, DTV телевизүүдээр дамжуулан сумдын соёлын өдрийн мэдээ мэдээллийг түгээж, сумдын урлагийн тоглолтыг шууд дамжуулан 109100 гаруй үзэгчдэд үзүүлсэн.

“Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийн хаалтын арга хэмжээг шилдгийн шилдгүүдээ тодруулан “Соёлын сэргэлт-2023” аяны нээлтийг тохиолдуулан 6-р сарын 19 ны өдөр “Эгшиглэнт говь-2023” гала тоглолт зохион байгуулж 162 ардын авьяастан оролцож танхимаар 500 гаруй хүн, шууд дамжуулалтаар 10,000 гаруй хүн үзсэн.

Аймгийн Засаг даргын А/331 тоот захирамжаар 18,760,000₮-ийг өргөмжлөл, шагналт байр болон шүүгчийн урамшуулалд зарцуулсан. “Эгшиглэнт говь” гала тоглолтын үеэр Соёл, урлагийн газрын нэрэмжит шагнал, Саран хөхөө театрын нэрэмжит шагнал, Музей сургалт судалгааны төвийн нэрэмжит шагналаа гардуулсан. Мөн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдийг урамшуулсан. Өвлөн уламжлагчдын тоо-50





МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ШАГНАЛТ, АРДЫН ЖҮЖИГЧИН, ЗУУНЫ МАНЛАЙ БҮЖИГ ДЭГЛЭЭЧ Ц.СЭВЖИДИЙН НЭРЭМЖИТ "ӨСВӨРИЙН БҮЖИГЧДИЙН УЛСЫН XVI НААДАМ"

Ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ой, "Нээлттэй Дорноговь" зорилтот жилийн хүрээнд хүүхэд, өсвөр үеийнхний авьяас чадварыг хөгжүүлэх, шинэ авьяастан төрүүлэх, бүжгэн дэгийн өв, урын санг баяжуулж сурталчлан таниулах, урлагаар дамжуулан хүүхэд багачуудад гоо зүйн хүмүүжил төлөвшил олгох, соёлын өв, уламжлалт бүжгийн урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор з Монгол Улсын төрийн шагналт, ардын жүжигчин, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит "Өсвөрийн бүжигчдийн улсын XVI наадам"-ийн удирдамж төсвийг боловсруулан хүргүүлснээр Аймгийн Засаг даргын А/283 тоот захирамжийн дагуу Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар, Соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Саран хөхөө театр хамтран Сайншанд хотноо 2023 оны 05 сарын 20,21 өдрүүдэд зохион байгуулан ажиллаа. Уг наадамд Дорноговь аймгийн 1,2,5 дугаар сургууль Magic dance бүжгийн клуб, Саруул дэнж бүжгийн клуб, Замын-үүд сумын 1,2 дугаар сургууль,



Айраг, Дэлгэрэх, Эрдэнэ сум Завхан, Говьсүмбэр, Хэнтий, Өмнөговь, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв зэрэг 8 аймаг Чингэлтэй, Баянзүрх, Багануур, Хан-Уул 4 дүүргийн нийт 654 хүүхэд хамтлаг бүжиг болон гоцлол бүжгийн төрөлд 3 насны ангиллаар бүртгүүлэн оролцлоо.

Наадмын бэлтгэл ажил зохион байгуулалтыг БШУГ, ГБХЗХГ, НБХ-тэй хамтран гүйцэтгэлээ. Бүжгийн наадмын шүүгчээр Урлагийн гавьяат зүтгэлтэн, МУАХ-ын Бүжгийн зөвлөлийн тэргүүн Ч.Даваасүрэн, Урлагийн гавьяат зүтгэлтэн, СУИС бүжгийн урлагийн сургуулийн захирал Д.Баярбаатар Ц.Сэвжидийн нэрэмжит Бүжгийн чуулгын тэргүүн А.Баярсайхан нар ажиллалаа. 2 өдрийн наадмыг 1500 гаран үзэгч хүүхдэд хүргэн шалгаруулах шатыг эцэг эхчүүд болон хүүхдүүдэд үнэ төлбөргүй сонирхууллаа. Шагнал урамшуулалд зориулан Аймгийн Засаг даргын 2023 оны А/283 -р захирамжаар 29,090,000 төгрөгийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлснээс гадна Хөдөлмөрийн баатар, бүжиг дэглээч Сэвжид агсны хүү Сүхбаатарт аймгийн Засаг даргын зүгээс хүндэтгэл үзүүлж



мөнгөн шагнал гардууллаа.

НОЁН ХУТАГТЫН ӨВ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл Урлагийн газраас санаачлан “Нээлттэй Дорноговь” зорилтот жил, Говийн Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ой тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг Олон Улсын эрдэм шинжилгээний VI хурлыг “НОЁН ХУТАГТЫН ӨВ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ” нэрийн дор 2023 оны 06-р сарын 09-ний өдөр Чингис Хаан үндэсний музейд амжилттай зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хурлын зорилго нь говийн ноён хутагт судлалд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хандуулах, судалгааны сүүлийн үеийн үр дүнг хэлэлцүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Ноён хутагтын өвийн үнэ цэнэ, ач холбогдлыг тодруулах, аялал жуучлал, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр

оруулахад орших бөгөөд хурлын нээлтэнд УИХ гишүүн Б.Дэлгэрсайхан, Т. Энхтүвшин, СУИС-ын Соёл урлаг судлалын хүрээлэнгийн захирал доктор (Sc.D), профессор Ч. Алтанцэцэг нар оролцож нээлтийн үг хэллээ. Тус хуралд Монгол, Орос, Хятад улсын 32 эрдэмтэн судлаачдын илтгэл хэлэлцүүлэгдэж Шинжлэх Ухааны эрдэмтэн багш нар, нутгийн алдартнууд Монгол Улсын Ардын Жүжигчин Г. Равдан, Монгол Улсын Төрийн Шагналт зохиолч Ш. Гүрбазар, Монгол Улсын Ардын Уран Зохиолч Б. Догмид зэрэг 160 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо.



"НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАВЖАА" УРАН БҮТЭЭЛИЙН УРАЛДААН

“Нээлттэй Дорноговь” зорилтот жил, Говийн Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан "Ноён хутагт Данзанравжаа" уран бүтээлийн уралдааныг зохион байгууллаа. "Ноён хутагт Данзанравжаа" уран бүтээлийн уралдаанд 28 уран бүтээлчийн 58 бүтээл ирснээс 23 бүтээлийг дэлгэн үзэсгэлэн гаргасан. Тус үзэсгэлэнд аймгийн удирдлагууд, уран бүтээлчид, иргэд зэрэг 150 гаруй хүн оролцсон.

Ноён хутагт Данзанравжаа” уран бүтээлийн уралдааны шүүгчдээр:
 Монголын урчуудын эвлэлийн ерөнхийлөгч - П.Ганбат
 Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Монголын урчуудын эвлэлийн гишүүн зураач -Н.Орхон
 Монголын урчуудын эвлэлийн гишүүн, Алтангас одонт зураач -З.Уянга
 Дүрслэх урлагийн академийн уран зургийн тэнхимийн эрхлэгч МУСТА,
 Монголын урчуудын эвлэлийн гишүүн зураач - Г. Амарсанаа

Монголын урчуудын эвлэлийн гишүүн, уран барималч - Б. Лхагважав нар ажиллаж, шилдгүүдээ тодрууллаа.

Энэхүү уран бүтээлийн уралдаанд:



Уран зураг төрөлд- Гаваагийн Төмөр

Уран баримал төрөлд- Насанбуянгийн Золжаргал

Зураасан зураг төрөлд- Д.Гунгаа

Гран при шагналыг – Бум-Эрдэнийн Баярцэнгэл

Ноён хутагт Данзанравжаа” уран бүтээлийн уралдааны нэрэмжит шагналаар: Буяннэмэхийн Түвшинтөр, Ганхуягийн Мөнхзаяа нар шалгарсан.



“ТУСГААР ТОГТНОЛЫН ДУУЛАЛ” ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ой, Монголын Зохиолчдын Эвлэлийн Дорноговь аймаг дахь салбарын нээлтийн үйл ажиллагаанд зориулсан "ТУСГААР ТОГТНОЛЫН ДУУЛАЛ" яруу найргийн наадмыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёл урлагийн газар хамтран зохион байгууллаа. Тусгаар тогтнолын дуулал яруу найргийн наадамд 24 яруу найрагч оролцож 3 үе шаттайгаар шилдгийн шилдгээ тодрууллаа.

- Тэргүүн байр-МЗЭ-ийн шагналт яруу найрагч А.Байгалмаа
- Дэд байр-Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, МЗЭ-ийн шагналт яруу найрагч А.Лхагва
- Гутгаар байр-МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Б.Аасүрэн
- Тусгай байр-Монголын зохиолчдын "Хутагтын Хурмаст тэнгэр" төвийн гишүүн, яруу найрагч Д.Эрдэнэзулай
- Тусгай байр-МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Б.Баярмөнх



“ОЮУ-АЙ” ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

“Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвөөс уламжлал болгон зохиодог хайрын шүлгийн “Оюу-Ай” яруу найргийн наадам амжилттай зохион байгуулагдлаа. Яруу найргийн наадамд Улаанбаатар, Дорноговь, Завхан, Дархан, Хөвсгөл, Дархан-уул, Хэнтий, Увс, Сүхбаатар, Говь-Алтай, Дундговь, Төв, Булган аймгуудаас 35 яруу найрагч шүлгээрээ уралдаж:

- Тэргүүн байрт Дорноговь аймгийн яруу найрагч Э.Анхбаяр
- Дэд байрт Хөвсгөл аймгийн яруу найрагч Ш.Бадамрагчаа
- Гуравдугаар байрт Дорноговь аймгийн яруу найрагч О.Алтангэрэл
- Тусгай байрт Булган аймгийн яруу найрагч Г.Хашбаатар
- Тусгай байрт Улаанбаатар хотоос оролцсон яруу найрагч С.Начин нар тус тус шалгарсан